



“БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Огноо:

2023.04.27

Дугаар 01

Улаанбаатар хот

Хэзээ, хаана: 2023.04.27-ны өдөр 15 цаг “Баянгол Ресторан”

Хурлын дарга З.Цэрэнчимэг: Сайн байцгаана уу, эрхэм хувьцаа эзэмшигчдээ
Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Хурал зохион байгуулах ажлын хэсэг томилогдож хурлын бэлтгэл ажлыг хангалаа.

Тус компанийн ТУЗ 2023 оны 03 дугаар сарын 20-ны өдөр хуралдаж, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2023 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 15:00 цагт тус зааланд зохион байгуулах шийдвэр гаргасан.

Уг тогтоолоор хурлаар Хэлэлцэх асуудлуудыг баталж, хурал зохион байгуулах комисс, тооллогын комиссыг баталсан.

Хурал зохион байгуулах комисс бэлтгэл ажлын хүрээнд “ТУЗ-ийн хурлаар батлагдсан “Хувьцаа эзэмшигчдэд Хувьцаа эзэмшигчдэд танилцуулах хурлын материалаа Монголын Хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороо зэрэг холбогдох газруудад хүргүүлж, 2023 оны 04 сарын 10-наас 2023 оны 04 сарын 27-ны хугацаанд, www.bayangolhotel.mn веб сайт, болон BAYANGOL HOTEL фейсбүүк фейжүүдээр шийдвэр гаргахтай холбогдох материалтай танилцаж, www.bayangolhotel.mn цахимаар саналын хуудсаа ирүүлэх болон хуралд биечлэн оролцож саналын хуудас бөглөх нөхцөлийг бүрдүүлсэн.

Мөн бүртгэлийн өдрийг 2023 оны 04 сарын 07 наар тасалбар болгон хуралд оролцох гишүүдийн бүртгэлийг Үнэт цаасны төлбөр тооцоо хадгаламжийн төвөөс гаргуулан авсан болно.

Хурлын зарыг “Өдрийн сонин”, “Монголын мэдээ сонин”-д тус бүр 2 удаа гаргаж, С1 телевизээр зар явуулж хувьцаа эзэмшигчдэд мэдээллийг хүргэсэн болно.

Ингээд хурал эхлэх бэлэн болсон учир тооллогын комиссыг ирцийн мэдээлэл танилцуулахыг урьж байна.

Тооллогын комиссын гишүүн, маркетингийн ахлах менежер Т.Дөлгөөн:

Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Хурлын ирцийг та бүхэнд танилцуулж байна. Баянгол зочид буудал ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 30-р хуралд 381,133 ширхэг хувьцаа эзэмшсэн 1067 хувьцаа эзэмшигчдээс 332,908 ширхэг хувьцааг эзэмшигчид оролцож, нийт хувьцааны 87,35% болсон тул компанийн тухай хуулийн 69.1-р зүйл, компанийн дүрмийн 7.4 зүйлийг үндэслэн хурлыг хүчин төгөлдөр тооцож байгааг мэдэгдэж байна.

Хурлын дарга З.Цэрэнчимэг:

За хурал хуралдах ирц хүрсэн учраас хурлын дэгийг танилцуулна уу хэмээн ТУЗ-ийн гишүүн Д.Батжаргалыг урьж байна.

ТУЗ-ийн гишүүн Д.Батжаргал:

За хурал хүчинтэй болж хурал эхэлж байна. Хурал эхэлж байгаа учраас хурлын дэгтэйгээ танилцаж, батлах ёстой. Хурлын дэгийг бүгдээрээ мэдэж байгаа. Ямар асуудлыг ямар хугацаатай ярилцах вэ гэдгийг тодорхойлж, дэгээр баталдаг.

- Хурлын тэмдэглэлийг Хүний нөөцийн ахлах менежер Г.Алт-Ундрах, нягтлан бодогч М.Гэрэлцогт нар бүрэн хөтөлж байна.
- Компанийн үйл ажиллагаа, санхүүгийн тайланг ТУЗ-ийн дарга Аюуш танилцуулахаар ирсэн байгаа. /20 мин/
- 2023 оны ТУЗ-ийн зардлын төсвийг Эдийн засагч Т.Удвал танилцуулна. /5 мин/
- Энэ жил ТУЗ-ийн зөвлөлөөс ногдол ашиг хуваарилахаар тогтоол гаргасан. Үүнийг ТУЗ-ийн дарга Аюуш танилцуулна. /3мин/
- Хурлын хэлэлцсэн асуудлаар санал хэлэх хүн тус бүр 2 минут
- Тооллогын комисс санал хураах ажиллагааг явуулаад, дараа нь хурал хаах ажиллагаа явагдана.

Хурал ийм дэгтэй зохион байгуулагдах юм байна. Хурлын дэгээ батлах уу?

Хуралд оролцогсод 100 хувийн саналаар гар өргөж батлав.

Тооллогын комисс "Саналын хайрцаг"-ийг нээж харуулан лацдав.

За дэгээ баталсан учир хурлын хөтөлбөрийн дагуу Компанийн үйл ажиллагаа, санхүүгийн тайланг ТУЗ-ийн дарга Аюуш танилцуулна уу.

ТУЗ-ийн дарга Аюуш:

Эрхэм хувьцаа эзэмшигчид та бүхний энэ өдрийн мэндийг хүргэе.

2022 оны компанийн үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, үүнтэй холбогдуулан гарсан ТУЗ-ийн дүгнэлтийг та бүхэнд танилцуулъя.

1. Компанийн тухай ерөнхий мэдээлэл өөрчлөгдөөгүй байгаа. Компани зочид буудал, зоогийн газрын үйл ажиллагаа эрхэлдэг, 1068 хувьцаа эзэмшигчтэй. 1964 онд байгуулагдсан, 1991 онд хувьцаат компани болон өөрчлөгдөн байгуулагдсан. 2004 онд 4 одны зэрэглэл авсан, үндэсний 100% хөрөнгө оруулалттай байгууллага, 2019 онд ISO 9001: 2015 буюу ОУ-ын ЧУС-ыг нэвтрүүлсэн Монголын анхны зочид буудал болсон. Нийтдээ 360 зочин хүлээж авах 5 ангиллын 260 өрөөтэй, 300-400 хүн хүлээж авах Баянгол ресторан, үндэсний хоолоор үйлчлэх МНӨ ресторан, дээд зэрэглэлийн виноны WH ресторанууд гээд бусад зочдод үйлчлэх дагалдах үйлчилгээнүүдийг дэлгэцээр дэлгэрэнгүй танилцуулав. Мөн:
 - Компанийн эрхэм зорилго
 - Алсын хараа
 - Зорилт
 - Компанийн зохион байгуулалтын бүтэц, бүдүүвч зураглал, эрх мэдлийн хуваарилалт, зохион байгуулалт Хавсралт №1
2. Мөн Ковидын үед цар тахлын эрсдэлийг бууруулах зорилгоор олон нийтээс тусгаарлах ажиллагааг Улсын онцгой комиссын нэгдсэн шуурхай албатай хамтран ажиллаж, нэгдсэн шуурхай албанаас талархал хүлээж авсан байгаа. Хавсралт №2

3. Бүтээгдэхүүн, үйлчилгээг сайжруулах талаар өнгөрсөн онд хийж гүйцэтгэсэн ажлууд болон тэмдэглэлт бүх баяруудыг алгасалгүй зохион байгуулсан арга хэмжээний үр дүнг жагсаалт, зургаар дэлгэрэнгүй танилцуулав. Хавсралт №3
4. Компанийн засаглалын талаар хийгдсэн шинэчлэлтүүдийг танилцуулав. Хавсралт №4
5. Компанийн санхүүгийн тайланг тоон үзүүлэлт, графикаар дэлгэрэнгүй танилцуулав. Хавсралт №5
6. 2022 онд Санхүүгийн зохицуулах хорооноос Компанийн засаглалын кодексыг шинэчилсэн байгаа. Энэ шинэчилсэн кодексст нийцүүлэн бид засаглалын дотоод журмуудыг шинэчилсэн. ТУЗ-ийн үйл ажиллагааны журам, Ногдол ашгийн бодлого, Хувьцаа эзэмшигчдийн хурлын журам, Мэдээллийн үйл ажиллагааны журам зэрэг хуучин 5 журмаа шинэчилсэн, дээр нь нэлээд хэдэн журмуудыг нэмж боловсруулан ажиллаж байна. ТУЗ маань хуульд заасны дагуу нийт 9 гишүүнтэй, үүнээс 3 нь хараат бус гишүүн байгаа. Компанийн хуулийн дагуу жил бүр хувьцаа эзэмшигчдийн хурлаа зарлаж, тухайн жилийн үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайлангаа тайлагнаж, Хараат бус аудитын дүгнэлтийг танилцуулж хэвшсэн байгууллага юм. Ер нь 1991.12.11-ний өдрийн Засгийн газрын өмч хувьчлалын 27-р тогтоолоор анхны хувь нийлүүлсэн зочид буудал болсон. Анх хувьцаат компани болсноосоо хойш хувьцаа эзэмшигчдийнхээ хурлыг 1 ч удаа таслалгүй зохион байгуулдаг ба өнөөдөр бид 30 дахь хурлаа хийж байна. Жил бүр ногдол ашиг хуваарилж ирсэн /ковидын жилүүдээс бусад жилүүдэд / нийт 2 тэрбум гаруй төгрөгийн ногдол ашиг хуваарилсан. 2022 онд ашигтай ажиллаж, ТУЗ-ийн 2023.02.15-ны өдрийн №05 тогтоолоор нэгж хувьцаанд 300 /гурван зуун/ төгрөгийн ногдол ашиг олгохоор шийдвэрлэсэн.
7. Компанийн үнэт цаасны мэдээллийг хүснэгтээр үзүүлж, дэлгэнгүй тайлбарлав. Хавсралт №6
Үүнээс 2022 онд хувьцааны мэдээлэл.
Манай хувьцааны дундаж ханш 31,8 мянган төгрөг
Хувьцааны тоо 423 мянга.
Нээлтийн ханш: 30 000 төгрөг
Хаалтын ханш. 30 000 төгрөг
Авахаар захиалга өгсөн дээд үнэ: 30 000 төгрөг
Зарахаар захиалга өгсөн дээд үнэ: 30 000 төгрөг
Манай хувьцаа арилжаалагдсан өдөр: 62
Нийт арилжаалагдсан хувьцааны тоо /энэ онд/: 43215 ш
Нийт арилжаалагдсан дүн: 1.4 тэрбум төгрөг
8. Орлого, үр дүнгийн талаар:
2018-2022 оны орлого, үр дүнгийн үзүүлэлтүүдийг графикаар харуулж, дэлгэрэнгүй мэдээлэв. Хавсралт №7
Тайлангийн үзүүлэлтээс харахад Борлуулалтын орлого өмнөх оноос 2,2 дахин өссөн, ашиг нэмэгдсэн /хөл хорио бүрэн тавигдсан/ нь оновчтой менежментээр ажилласны үр дүн юм. Улсад нийтдээ 1,2 тэрбум төгрөгийн татвар төлсөн байна.

9. 2023 оны үндсэн 4 зорилтыг хүснэгтээр үзүүлж, дэлгэрэнгүй тайлбарлав.
Хавсралт№8

9.1 Эерэг хандлага-эрүүл ажилтан

- Ажилтнуудыг тогтвор суурьшилтай ажиллуулах хөтөлбөр
- Ажилтнуудын гүйцэтгэлийн үнэлгээг хэрэгжүүлэх
- ISI Стандартын хүрээнд ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг стандартын дагуу боловсруулах
- Ажилтнуудын цалинг нэмэх
- Баг нэгжийн зохион байгуулалтыг сайжруулах, үр дүнгийн хурал тогтмолжуулах

9.2 Найрсаг, тогтвортой харилцаа

9.3 Харилцааны үр чадвар, үйлчилгээний ажилтан

Зочноо дээдэлж, ажилтнаа хүндлэн, зочлох үйлчилгээгээр манлайлагч байх

9.4 Үр ашиггүй зардлыг хэмнэх

За ийм үндсэн зорилтуудыг хэрэгжүүлж ажиллаж байна. Та бүхэнд тараасан материал дотор 2022 оны санхүүгийн тайлан, Сэрэлт-дөл аудитын компаниас ирсэн санхүүгийн аудитын дүгнэлтийг оруулсан байгаа. Гол дүгнэлт нь 2022.12.31-ний өдрөөр тасалбар болгосон орлого, үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ нь ОУ-ын стандартын дагуу мөнгөн дүнгээр үнэн зөв, шударгаар илэрхийлэгдсэн байна гэж дүгнэсэн, эерэг дүгнэлт авсан байгаа. ТУЗ-ийн зүгээс Гүйцэтгэх удирдлага нь хангалттай сайн ажилласан байгаа гэж дүгнэсэн байгаа. За ингээд та бүхэндээ танилцуулах зүйлүүдээ дуусаж байна. Хөтөлбөрийн дагуу асуулт, хариултдаа орьё.

ТУЗ-ийн гишүүн Д.Батжаргал:

Дэгийнхээ дагуу 2023 оны ТУЗ-ийн төсвийг танилцуулна уу гээд эдийн засагч Т. Удвалыг микрофонд урья.

Эдийн засагч Т.Удвал:

Сайн байцгаана уу, Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. 2023 оны ТУЗ-ийн зардлын төсвийг танилцуулъя. Үүнд:

- ТУЗ-ийн гишүүдийн цалин, жилээр: 22,680,000 төгрөг. Үүний НДШ 2,835,000 төгрөг
- ХЭЗ-ийн 30-р хурлын зардал 4,141,200 төгрөг.
- Хөрөнгийн биржийн хураамж 1,200,000 төгрөг. Ингээд нийт дүн нь 30,815,412 төгрөг бөгөөд сүүлийн жилүүдэд төсөвт өөрчлөлт ороогүй болно.

ТУЗ-ийн гишүүн Д.Батжаргал:

Хурлын дэгийн дагуу дараагийн асуудалдаа орьё. Хурлын дарга Б.Аюушийг урья.

ТУЗ-ийн дарга Б.Аюуш:

За би түрүүнд танилцуулгадаа мөн дурьдсан байгаа. ТУЗ-ийн 2023.02.15-ны өдрийн 05 тоот тогтоолоор Нэгж хувьцаанд 300 төгрөгийн ногдол ашиг олгохоор шийдвэрлэсэн. Үүнийг та бүхэндээ дуулгахад таатай байна.

ТУЗ-ийн гишүүн Д.Батжаргал:

Баталсан дэгийн дагуу санал хүсэлтээ чөлөөтэй хэлж болно. ТУЗ болон удирдлагаас асуух асуулт, санал хүсэлт байвал чөлөөтэй хэлнэ үү.

Мөн тооллогын комиссыг ажилдаа орохыг урья. Дараа нь тооллогын комиссын дүнг сонсоно.

Хувьцаа эзэмшигч Энхрийлэнгийн төлөөлөгч /Жавхлан аав нь/

Асуулт 1 :

Сайн байцгаана уу. Би Энхрийлэнгийн аав Жавхлан гэж хүн байна. Манай хүүхэд 34 ш хувьцаатай. Үүгээрээ юу хэлэх гээд байна вэ гэвэл хүүхдүүддээ бас ийм найдвартай, үнэлгээ өндөр компанийн хувьцаатай болгохыг зорьсон юм.

1-р асуудал: Байгууллагын зорилго энгийн байна. Зорилго нь үйлдлийн "Х" үсгээр төгсөхөөр байгууллагуудын үйл ажиллагаа төгсөшгүй үргэлжлэх мэтээр тодорхойлогддог юм шиг санагддаг. Үүн дээрээ анхаараарай.

Мөн алсын хараагаа тодорхой болгоорой. Цаашид юу харж байгаагаа илүү тодорхой болгох хэрэгтэй санагдлаа.

Жилийн баяруудыг алгасалгүй зохион байгуулсан нь харагдлаа. Үүн дээр гүн талархал илэрхийлье. UFC –залуучуудын сонирхлыг их татаж байгаа. Том талбайгаа ашиглан, зохион байгуулсанд талархал илэрхийлье. Март, Валентин, UB comedy гээд оновчтой арга хэмжээ зохион байгуулж, өөрсдийнхөө борлуулалтыг нэмж чадсанд та бүхэнд баярлалаа. Үүнийгээ цаашид ашиглаад Монгол улсад байнга баяр тэмдэглэдэг бол түүнийг сул тал биш давуу тал болгон ашиглаж, ажиллах нь зөв зүйтэй гэж үзэж байна. Ногдол ашгийн хувьд зах зээлийн үнэлгээ 30,000 төгрөгөөс өндөр байна. Яагаад гэвэл 2 том барилга, 2 том ресторан, газар гээд үнэлгээгээ үзэхээр нийт үнэлгээ 18 тэрбум байсан. Үнэлгээгээ нэмж хийлгэсэн байгаа юу. Санхүүгийн зохицуулах хорооны журамд үнэлгээгээ 2 жил тутамд хийлгэх ёстой гэж харагдсан. Байгууллагууд болохоор татвар болон бусад асуудлаас шалтгаалан үнэлгээгээ хийлгэдэггүй гэсэн мэдээлэл байдаг. Энэ нь хэр үнэний ортой байдаг юм. Бид үнэлгээгээ хийлгэснээр илүү үнэтэй харагдана. 18-хан тэрбум төгрөгийн үнэтэй ийм том объект, газар гэж байхгүй. Жижигхэн зүйл хийхэд өчнөөн тэрбум болчихдог ш дээ. 220 мянгатын зам дагуу ийм том газар гэхээр үнэлгээний аргачлалын дагуу өртгийн арга, зах зээлийн хандлага, орлогын хандлага гээд бүх хандлагаар маш өндөр үнэлгээтэй харагдахаар байгаа. Энэ үнэлгээгээ хийлгэчихвэл хувьцааны зах зээлийн ханш 30,000 төгрөг, үнэлгээгээр тогтоогдсон буюу нийт үнэлгээнээс өр төлбөрийг нь хасахаар эздийн өмч гарна, эздийн өмчөө нийт хувьцаанд гарахаар дансны үнэ гарна. Тэр дансны үнийг зах зээлийн ханштай харьцуулахаар одоогоор дансны үнэ нь 56,000 төгрөг, миний тооцоолж байснаар гарч байна. Тэгэхээр 56,000 төгрөгийн үнэтэй байх хувьцаа өнөөдөр 30,000 төгрөгийн үнэтэй байна гэдэг бол хямдхан байна. Үүнийг хүмүүс ойлгох юм бол маш шуурхай хурдан худалдан авахаар байгаа. Нэг бол үнэлгээгээ хийлгэвэл энэ 56,000 төгрөг бүр илүү үнэтэй харагдсанаар хувьцааны ханш чинь өсөх юм биш үү. Үүнтэй холбогдуулаад шинэ хувьцаа эзэмшигч бий болох, давуу тал болгон ашиглах боломж байна.

KPI нэвтрүүлэх талаар ярилаа. Тухайн ажилтныг хэрхэн сайн ажиллуулах түлхүүр гэсэн утгатай гэж би ойлгодог. Бусад газрууд цалинг нь буруулж байгаад, KPI нэмж өгөөд байдаг. Танай цалингийн зардал нэлээд өндөр юм байна ш дээ. Цалингаас нь хасахгүйгээр KPI нэвтрүүлбэл ажилчид илүү сэтгэл ханамжтай байх юм болов уу гэж бодож байна. ТУЗ-ийн цалин бол бага байна. 30 сая гэсэн үү. ТУЗ улирал тутам хурлаа хийдэг байх. Тэгэхээр цалингийн доод хэмжээ нэмэгдсэн байх, ТУЗ цалингаа нэмэгдүүлээд, тэгэхээр бид буцаагаад хариуцуулах хариуцлагаа яриад явбал зөв юм болов уу. За шинэ 1 юм гэвэл CRM-Customer relationship management. Тухайн харилцагч орж ирлээ, энэ ерөөсөө ийм өрөө авдаг, энэ хүн ерөнхийлөгчийн өрөө авдаг, энэ хүн манайхаас машин түрээсэлдэг гэх мэтчилэн харилцагчаа таньдаг, бүртгэдэг, CRM-/Customer relationship management/ ээ мэдчих юм бол манай буудлаар тийм хүн орж ирлээ, энэ хүн тэдэн сая төгрөгийн орлого оруулна аа гэдгийг урьдчилан тооцоолбол хэрэгтэй юм болов уу. Нэгэнт KPI нэвтрүүлж байгаа юм чинь CRM-ээ давхар нэвтрүүлчхээрэй гэсэн ийм л хүсэлт байна. За баярлалаа, та бүхэнд амжилт хүсье

Хариулт:

ТУЗ-ийн дарга Б.Аюуш:

За танд их баярлалаа. Үнэтэй, сайхан зөвлөгөө өглөө. Алсын хараа, зорилго, зорилтоо бид шинэчлэх хэрэгтэй байгаа. Манай алсын хараа, зорилго, зорилт үнэхээр таны шүүмжилснээр оновчтой биш байгаа. Үүнийгээ бид энэ ондоо багтааж өөрчилж, шинэчлэхээр зорьж байгаа. За дараагийнх нь үнэлгээний талаар ярьсан. Үнэлгээний талаар ярихад амьдрал дээр хүндрэл бэрхшээл байдаг. Үнэлгээ нь нэлээд үнэтэй үйлчилгээ. 2 жил тутамд үнэлүүлэхэд үнэхээр амжихгүй, үр ашиггүй зардал их гардаг. Тэгэхдээ бид 2023 оны эцсээр үнэлгээ хийлгэхээр манай төлөвлөгөөнд байгаа. Мэдээжийн хэрэг энэ 2 том барилга, 2 том рестораны үнэлгээ бодит байдалд нийцэхгүй байгаа гэдэг нь үнэн. Үнэлгээ энэ онд хийлгэнэ. Үнэлгээ бол хэд хэдэн сөрөг үр дагавар дагуулдаг. 1. Үнэлгээ хийлгэх процесс өөрөө бас үнэтэй байдаг. Тэгээд бас үр ашиггүй зардал гэж үзээд байгаа. Тэрэндээ бас бидний бодол алдаатай байж магадгүй. Дээрээс нь үнэлгээ хийлгэчихээр үл хөдлөх хөрөнгийн татварын хэмжээ маш их нэмэгддэг. Үр ашиггүй зардал гэсэн үг л дээ. Энэ бол амьдрал дээр тохиолдож байгаа бэрхшээл. KPI талаар бол бид мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулчихсан. Энэ оны 4 сарын 01-ний өдрөөс нэвтрүүлээд туршаад эхэлсэн байгаа. Үр дүнтэй байна гэсэн өндөр хүлээлттэй байгаа. За ТУЗ-ийн цалингийн хувьд үнэхээр бага байгаа. Тэгэхдээ бид компанийн эрх ашгаа бодоод, сүүлийн 10-аад жил өөрчлөлт оруулаагүй байгаа. Манай ТУЗ тогтвортой үйл ажиллагаа явуулдаг. Д.Батжаргал ТУЗ-ийн гишүүн зэрэг 30 дахь жилдээ манай ТУЗ-д ажиллаж байгаа хүмүүс байгаа. CRM-ыг нэвтрүүлнэ. KPI –ынхаа үр дүнг харж байгаад, нэвтрүүлъя. Компанийнхаа үйлчилгээний чанар, ажиллагсдынхаа тогтвор суурьшилд дээр их анхаарч байгаа. Ажилтнуудын тогтвор суурьшил муу байгаа. Ер нь Монголын ихэнх компанид энэ асуудал хүндрэлтэй байгаа. Ажиллах хүчний олдоц муу байна.

Хариулт:

ТУЗ-ийн гишүүн Д.Батжаргал:

За би удирдах зөвлөлийн хараат гишүүний хувьд саяын саналыг сонсож суухдаа хувь нэмрээ оруулах үүднээс бодогдсон зүйл, саналаа хэлье гэж бодлоо. “Эерэг хандлага-эрүүл ажилтан” гэдэг зорилт тавьж байгаа. Энд орж ирж байгаа үйлчлүүлэгчид эрүүл ажилтан үйлчлэх ёстой. Би өөрөө СЭЗИС-ийг төлөөлж байдаг. Тэнд “Эрүүл энхийн нэгэн жаргалан” гэдэг хөтөлбөр зайнаас явдаг. Энэ хөтөлбөрийг Баянгол зочид буудлын ажилтнуудад санал болгохоос гадна хувьцаа эзэмшигч та бүхэнд бас санал болголоо гэж бодож байна. Та бүхний цахим хаяг чинь байгаа учраас эрүүл байхыг хүсэхгүй хүн байхгүй учраас та бүхний цахим хаягаар энэ хөтөлбөрийг санал болгоё гэж бодож байна. КРІ-д энэ үзүүлэлтийг зайлшгүй оруулах нь зүйтэй гэж үзэж байгаа. Иймэрхүү байдлаар бид 2023 оныг их өөдрөгөөр төсөөлж байгаа. Та бүхэн харж байгаа байх. Төр засгийн зүгээс ба нэлээд анхаарч байгаа. Монголд зочлох жил гээд зарлачихсан. Удахгүй эхлэх гэж байгаа учраас бид бэлдэх хэрэгтэй. Гадаа шуурч байгаа шуурга шиг хуйсганаад байж болохгүй. Бүгдээрээ хамтдаа эвтэй, эетэй хамтарч ажиллаж, амьдарцгаая.

Асуулт 2:

Хувьцаа эзэмшигч Энхбаяр:

Би Баянгол зочид буудлын хувьцааг мөнгөөрөө худалдаж аваад 30 жил болж байна. 30 жил болоход хувьцааг 1,700 төгрөгөөр эхлээд авч байсан. Ойрын 5 жил 30,000 дээр тогтсон. Эхний жилүүдэд бол хүнд байсан. Өнөөдөр ресторан маань сайхан болж байна. Гэхдээ хувьцаа эзэмшигч миний зорилт бол биелээгүй. Яагаад гэвэл гадаадад ч тийм байдаг, монголд ч ийм олон компаниуд бий, нэгж хувьцаанд оногдож байгаа, тарааж буй ашиг 5 жилд нугарахаар бол стандартын гэж үзэх гээд байдаг. Гэтэл 35000 төгрөгийн үнэтэй хувьцааг 300 д хуваахаар заана шиг амьтанд бол ашгийг нь хүртэж болох талтай /инээв/. Батжаргал гэж санхүүч байна нэгж хувьцаанд ногдох ашгийг өндөрсүүлэх хэрэгтэй. Тэгж байж энэ хувьцаа чинь хүнд хэрэгтэй болно. Та нарын хувьцааныхаа өгөөжийг яаж нэмэгдүүлэх гэж байгаа вэ? Өнгөрсөн жил хэдэн төгрөгийн нийт ашгаас, нэгж хувьцаанд хэдэн төгрөг оногдож байгаа вэ. Нийт ашгаа 423,065 буюу хувьцааны тоондоо хуваахаар хэд болж байгаа вэ?. Дахин нэг асуулт асууя. Ковидоос өмнө Баянгол ресторанд 2,3 төрлийн хөрөнгө оруулсан байх. Саун, бусад үйлчилгээ гээд. Тэнд Монгол улсын тамирчид их үйлчлүүлдэг. Энүүгээрээ хэдэн төгрөг олдог вэ. Эсвэл үнэгүй байлгадаг юм уу ?

Хариулт:

Хурлын дарга З.Цэрэнчимэг:

Сүүлийн асуултад хариулъя. Яг тамирчдаас хэдэн төгрөгийн ашиг олдог вэ гэдгээ бид нар бэлдээгүй учраас шууд хэлэх боломжгүй байна. Хуучин бол Баянгол, Улаанбаатар, Чингис гэдэг байсан бол одоо бол маш олон шинэ өрсөлдөгч нар бий болсон учир бид зах зээлээс аль болох үйлчилгээгээрээ үйлчлүүлэгч татаж авдаг. Өнгөрсөн 2 жил МУ-д жуулчин ерөөсөө орж ирээгүй, 2022 оны 5-р сард хилээ нээсэн. Бид нарын гол орлогыг тамирчид бүрдүүлдэг. Одоо 6.7.8 саруудад тус бүр бид тамирчдыг хүлээж байна. 8-р сард Зүүн Азийн олимпын тамирчид ирэхээр болсон

байгаа. Ийм бөөнөөрөө ирдэг хүмүүсийг хүлээн авч, буудлынхаа гол орлогыг бүрдүүлж байна. Ресторанаараа олон арга хэмжээ зохион байгуулж, орлогоо бүрдүүлж байна. Өнгөрсөн 2 жилд ковидын үед хаалгаа хаах үедээ хаалгаа хааж, орлогогүй үедээ ажилчдаа тогтоон барих үүднээс цалин өгч, хэдэн ажилчдаа авч үлдсэн. Одоо ажиллах хүч хангалтгүй, олддоггүй. Сайхан үйлчилгээ үзүүлье гэхээр ажиллах хүч олддоггүй, чаддаггүй. Ганц манайх биш аялал жуулчлалын салбарт бүхэлдээ чадварлаг ажиллах хүчний хомсдолтой байна. Тэгэхдээ бид аль болох ажилчдаа мэргэшүүлж сургах, төлөвшүүлж, үйлчилгээгээ өргөжүүлэх зорилт тавиад ажиллаж байна. Тэгэхээр бидний гол орлогыг бүрдүүлдэг хүмүүс бол бөөнөөрөө ирдэг тамирчид, рестораны арга хэмжээ гэж ойлгож болно. Энэ жилээс цөөн тооны жуулчны компаниуд жуулчдаа оруулж ирэх боломжтой боллоо гээд холбогдсон. Хуучинтайгаа харьцуулахад захиалга буурсан байгаа. Ашгийг хувьцааныхаа тоонд хуваахад 5910 төгрөг болж байна. Тэгэхдээ та бас ойлгоорой, бид 2 жил алдагдалтай ажилласан хурлаа онлайнаар хийфсэн, энэ жил ямар ч байсан хувьцаа эзэмшигчидтэйгээ хурлаа хуучин уламжлалаараа зохион байгуулахаар шийдвэрлэсэн байгаа. Ихэнх газрууд онлайнаар хурлаа хийж байгаа. Бид тэгэхдээ хурлаа хийе, уулзъя гэсэн зорилго тавьсан учраас өнөөдрийн хурлын зохион байгуулсан. Бас ямар ч байсан бид ногдол ашгаа хүртээе ээ гэсэн учраас 300 төгрөг хуваарилсан. Зочид буудал маань хуучирч маш их хөрөнгө оруулалт шаардагддаг, мөн тоног төхөөрөмжүүдээ бүгдийг нь засах хэрэгтэй байдаг. Сайн үйлчилгээ үзүүлэхийн тул цэвэрлэгээ, үйлчилгээ тав дух сайн байх түүнийг дагаад үйлчлүүлэгчтэй байх тул засвар үйлчилгээ, цэвэрлэгээний зардал их гардаг гэдгийг та бүхнийг ойлгож байгаа байх аа гэж бодож байна.

Хувьцаа эзэмшигч Энхбаяр:

Саяын тайлангаас харахад яг үйл ажиллагааны ашгаараа бүртгэвэл 6 жилд нугалах ашиг олж байгаа юм л даа, 5910 төгрөг гэж үзвэл. Энэ л уг нь бол гол үзүүлэлт. Гэтэл энэ үзүүлэлт хувьцаа эзэмшигч надад, би бусад хүний өмнөөс бол ярихгүй, надад өгөөжөө өгөхгүй байна уу. Энийг бол ТУЗ-ийн дарга, ТУЗ-ийн гишүүд хэдийгээр бага хувьцааг эзэмшдэг ч гэсэн зах зээлийн зарчмаараа нэлээд ширүүхэн үзэж, ирэх жилүүдэд ногдол ашгаа 1000 төгрөг, 1500 төгрөг болгох, гадаадын компаниуд улирал тууам, жилд 4 удаа хувааж байна, Монголд одоо жилд 2 хуваадаг болж байна. Танайх хамгийн төвд нь байдаг, танай үнэ жоохон муу байна аа. Тэр зардал чинь 5,6 тэрбум байхад түүнд ногдсон үнэ жаахан муу байна аа. Сошиал орчинд танай хувьцааг муухан байна гэж бичээд байгаа шүү. Бас нэг анхаарах хэрэгтэй үүн дээрээ. Жаахан үнээ нэм л дээ, ийм сайхан цөөхөн хүн амтай, зочид хүлээж авдаг, хотын төвд байдаг. Үнэ ханш дээрээ анхаармаар байна. Миний зорилго бол энэ. Амжилт хүсье.

Хурлын дарга З.Цэрэнчимэг:

Таны хэлж байгаад анхааръя. Бид 400 гаруй хувьцаат компаниас нь хэд нь ингээд ногдол ашиг хуваарилж байна вэ гэдгийг судалж үзэж байсан. Тогтмол ногдол ашгаа өгдөг 10 гаруй компанийн нэгэнд манайх ордог юм билээ. Их, багийн хувьд таны хэлж байгааг ойлголоо. Бид анхаарч ажиллая. Брокерын пүүс, хөрөнгийн зах зээл дээр ажилладаг хүмүүс мэдэж байгаа байх.

Асуулт 3:

Хувьцаа эзэмшигч Л.Цэвээнравдан:

За сайн байцгаана уу. Хурлын материалтай холбогдуулаад ганц нэг зүйл асууя. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хувьцаа эзэмшигчдэд ямар мэдээлэл өгөх вэ гэдэг асуудал чинь журамлагдсан байгаа ш дээ. Хорооны журмууд байна. Тамгын засаглалын кодексууд бас байж байна. Энэ материалаас харахад дор хаяхад өнгөрсөн жил 22 онд ч юм уу ямар төлөвлөгөө тавьсан, тоон үзүүлэлтүүд алга, аягүй сайхан өгүүлбэрээр бол байна. Энэ нь өөрөөр хэлбэл хувьцаа эзэмшигчдэд хүрэх ёстой мэдээлэл цагтаа хүрэхгүй байна. Хувьцаа эзэмшигчид тоог харж байгаад, тодорхой хэмжээнд дүгнэлт хийх ёстой. Цаашлаад хөрөнгө оруулалтын шийдвэр гарах ёстой. Энэ хурлын материалаас жилийн ажлын үр дүн дээр дүгнэлт хийх ёстой. Жилдээ нэг удаа л хурал хийж байгаа ш дээ. Эндээс хэлэхэд 2022 онд орлогын ямар төлөвлөгөө тавьсан бэ. Компанийн нийт зардал хэд байсан юм. Тэгээд яаж биелсэн юм. Биелсэн бол ямар учир шалтгаанаас биелсэн юм. Зардал хэдээр биелсэн юм. Яагаад зардал ихэссэн юм. Яагаад зардал хэмнэгдсэн юм. Ашгийн төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө гээд эднийг задалж, хувьцаа эзэмшигчдэд хүргэх ёстой байгаа юм. Тэрнээс бол компанийн үйл ажиллагааг рекламдах биш, бид хувьцаа эзэмшигчид болохоос биш, үйлчлүүлэгч биш. Хурлын зорилт бол компанийн эздийн хурал. Тийм учраас компанийн сайн, мууг энэ хурал дээр ярих ёстой гэж би хувьдаа бодож байгаа. Том том хэлцлүүд хийгдсэн байж болно. Тэр бүгд чинь компанийн засаглалын кодексоор, энэ хурал дээр тайлбарлаж байх ёстой байх нь. Бид нар яах вэ, жижиг хувьцаа эзэмшигчид, нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид биш. Гэхдээ бид нарт энэ компанийн бодит байдал хэрэгтэй, тоон үзүүлэлтээрээ. 2023 оны төлөвлөгөөгөө та бүхэн ТУЗ-өөрөө хуралдаад тавьсан байгаа байх. Ирэх жил ямар орлого олох гэж байгаа юм. Ямар зардал гаргах гэж байгаа юм. Ямар хөрөнгө оруулалт хийгдэх гэж байгаа юм. Яагаад 300 төгрөг өгч байгаа юм. Яагаад олсон ашгаа бүгдийг нь хуваарилахгүй байгаа юм. Аль эсвэл жаахныг нь өгчхөөд, үлдсэнийг нь хөрөнгө оруулалт хийх гэж байгаа бол хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнүүд. Жил бүр нийт ашгийнхаа бараг 70-80 хувийг нь авч үлдээд, хөрөнгө оруулалт хийж байгаа. Тэгвэл 5-10 жилийн хөрөнгө оруулалтын үр дүн одоо байна уу, байхгүй байна уу. Үүн дээр тоон үзүүлэлт ерөөсөө гарахгүй байна. Одоо энэ хурлаар 2023 оныхоо төлөвлөгөөг хэлчихвэл дараа жил бид нар хуралд суухдаа төлөвлөгөөний тэр нь биелж, тэр нь тасарсан байна. Ийм шалтгаанаас гээд бид асуудыг мэдэж баймаар байна. Дээр нь компанийн засаглалын кодексоор бол тухай бүрд нь мэдээлэх мэдээлэл байдаг. Том хэлцлүүд хийгдсэн үү, охин компани байгуулах уу. Танай веб сайт дээрээс, Хөрөнгийн бирж дээр тавигдсан веб сайт дээрээс иймэрхүү мэдээллүүд тун харагдахгүй байгаа. ТУЗ зөндөө ажил хийсэн байх, зөндөө тогтоол шийдвэр гаргасан байх. Тэр дотор чинь компанийн үнэ ханшид нөлөөлөх мэдээллүүд байгаа байх. Бидэнд хөрөнгө оруулалт хийхэд шаардлагатай мэдээллүүд хангалтгүй байна. Түрүүний хүн бас хэлж байна. Ногдол ашгаараа, үнэ ханшны өсөлтөөрөө ашиг болж болно гээд. Гэтэл манай энэ хувьцааны жилийн арилжаа маш цөөн, үнэ өндөртэй. Тийм учраас ТУЗ-ийн зүгээс том хувьцаа эзэмшигчдээс хувьцааг нь хуваах асуудлыг анхааралдаа авч үзнэ үү. Ингэвэл арилжаа

идэвхтэй болно. Гэх мэтчилэн арилжааг идэвхжүүлэхэд анхаараарай. ТУЗ-ийн гишүүдэд туршлагатай, олон жил ажилласан хүмүүс байна, СЗХ-нд удирдах ажил хийж байсан хүмүүс байна, бизнесийн том удирдлагууд байна. Энэ хүмүүс чин сэтгэлээсээ ажиллавал өшөө их амжилтад хүрнэ гэж бодож байна. За баярлалаа.

Хурлын дарга З.Цэрэнчимэг:

Таны тавьсан санал, асуултад баярлалаа. Би нэг товч тайлбар хэлье, бусад хүмүүст ч хамаатай болов уу. 1. Бид оны эхэнд бизнес төлөвлөлт, үйл ажиллагааны төлөвлөгөө орлого, зардал, сургалт, эрсдэл гээд бүх төрлөөр нь 5,6 төрлөөр төлөвлөж, ТУЗ-өөр батлуулдаг. Түүнийгээ хэрэгжүүлэхийн төлөө алба бүр өөрийн төлөвлөгөө гарган ажилладаг. Яагаад энэ мэдээллээ танилцуулах мэдээллээ оруулаагүй вэ гэхээр Хөрөнгийн биржид бүх хувьцаат компани өөрийнхөө үйл ажиллагаа, хөрөнгө оруулалт, гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлангаа дэлгэрэнгүй тавьдаг. 2. Засаглалын кодексийн үнэлгээг өнгөрсөн жил гаргасан учраас бид тэнд засаглалын кодексоо мөн тавьсан байгаа. Хөрөнгийн биржийн сайт дээр санхүүгийн тайлан, аудитын тайлан бүрэн эхээрээ нийтийн мэдээлэл болоод тавигдсан байгаа учраас бид нийтэд тавигдсан мэдээллийг товч танилцуулгадаа оруулаагүй. Шаардлагатай мэдээллээ Хөрөнгийн биржийн сайтаас авч үзээрэй. 3. Бидний сая ярьсан гүйцэтгэл бол 2023 оны төлөвлөгөө биш, 2022 оны төлөвлөгөөний биелэлтээ сая ярьсан. Бид 2023 онд төлөвлөгөөг аль болох өсгөж тавьдаг. Жишээ нь өнгөрсөн жилийн орлогыг 23%-иар өсгөхөөр, 9.5 тэрбум төгрөгийн орлого хийхээр төлөвлөөд, биелүүлэхээр зорьж ажиллаж байна. KPI-д нарийн тусгасан, хоолныхоо нэр төрлийг нэмэгдүүлж, олон төрлийн хоолоор үйлчлэх гэх мэт тодорхой үзүүлэлтүүд оруулж, манай удирдлагын баг ажиллаж байгаа. Эдгээр үйл ажиллагаа маань ТУЗ-ийн шийдвэрийн дагуу явагдаж байгаа.

Асуулт 4:

Хувьцаа эзэмшигч Амарсайхан:

За асуух гэж байсан асуултад сая хариулчихлаа даа. Одоо энэ барилгынхаа гадаад үзэмжид яаж анхаарах гэж байна даа. А зэрэглэлд байдаг учраас өнгө үзэмж хэрэгтэй.

Хурлын дарга З.Цэрэнчимэг:

Таны хэлж байгаа бол үнэхээр үнэн. А зэрэглэлд байдаг, гадаад, дотоод үзэмжидээ анхаарах ёстой байдаг. Дотооддоо бол бага, багаар хийж явдаг. Гадаад үзэмжийн хувьд хуучин хэв шинжийг хадгалах байх аа. Будах, засах ажлыг бага, багаар хийгээд явж байгаа. Өндөр дүнгээр хийлгэх гэхээр өртөг, зардлын асуудал байдаг. Хэсэгчилж хийгээд явж байгаа.

Асуулт 5:

Хувьцаа эзэмшигч Эрдэнэцэцэг:

Сайн байна уу. Би танай хувьцааг 1992 оноос хойш эзэмшсэн, жижиг хувьцаа эзэмшигч. Танай хуралд 1997 оноос хойш тасралтгүй сууж байгаа. Төрийн мэдлийн 40% хувьцаа байсан хувьчилсан. Дараа жил нь хураад дээр Мах импексийн хувьцааг авсан гэж байсан. Та нар бол Мах импексийн давхар хувьцаа эзэмшигч шүү гэж байсан. Дараа жил нь Мах Импексийн ХЭХ дээр очиход та нар хувьцааг гаднаас худалдаж авбал ХЭ болно гэж байсан. Тэгэхээр Баянгол Махимпексийн хэчнээн хувьцааг авсан юм. Бид нар давхар хувьцаа эзэмшигч нь мөн юм уу, биш юм уу. Тэрнээс ямар ашиг олдог вэ. Түрүүчийн хүмүүсийн хэлсэнчлэн 30 жилийн өмнө өгч байсан 300 төгрөг чинь яагаад дээшээ, доошоо болдоггүй юм. Баянгол ресорт гэж шинэ салбар байгаа юм уу.

ТУЗ-ийн дарга Аюуш:

За би хариулъя. Ер нь төрийн мэдлийн хувьцаа гэж огт байгаагүй. Та буруу ойлгосон юм шиг байна. Мах импексийн хувьцаа авсан гэж сонсоогүй юм байна. Хэрэв Мах импексийн хувьцааг эзэмшдэг. Компани Махимпексийн хувьцааг авсан бол компани өөрөө л хувьцаа эзэмшигчээр явна. Баянгол ресорт компанид хөрөнгө оруулалт хийсэн. Баянгол ресорт компанийн тодорхой хувийг эзэмшиж байгаа. Тэр компани дөнгөж үйл ажиллагаа эхэлж байгаа учраас ашиг олж, манайд ногдол ашиг өгч эхлээгүй байгаа. Гэхдээ ойрын 3-4 жилээс бид тэр компаниас ногдол ашиг авна гэж төлөвлөж байгаа. Тэр компанийн хувийн хэвшилтэй хамтран байгуулсан. Уг компанид 10-аад жил хөрөнгө оруулалт хийж явж байгаад, өнгөрсөн жил ашиглалтад оруулсан Одоо 2 дахь жилдээ үйл ажиллагаа нь дажгүй, гайгүй явж байгаа. Тэгэхдээ тэндээс бид одоохондоо ашиг олж эхлээгүй байна аа.

Хурлын дарга З.Цэрэнчимэг:

Өөр асуулт, санал байгаа юу. Өөр асуулт, саналтай хувьцаа эзэмшигч байна уу. Байхгүй бол тооллогын комиссыг ажилд нь оруулж болж байна уу.

За тэгвэл тооллогын комисс ажилдаа орё. Саналын хуудсан саналаа бөглөөд, тооллогын комиссын танилцуулж байгаа хайрцагт хийх юм шүү. Саналаа өгөхийнхөө хажуугаар шинэ зочид буудлын танилцуулга явж байгаа. Танилцаарай.

Хурлын дарга З.Цэрэнчимэг:

Тооллогын дүн танилцуулна уу хэмээн тооллогын комиссын дарга Д.Самданжамцыг урья

Тооллогын комиссын дарга Д.Самданжамц:

1. Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах асуудлаар нийт өгсөн саналын тоо 332,905 үүнээс татгалзсан нь 84,610, хүчингүй 3, зөвшөөрсөн 248,292, нийт саналын 74,58% болсноор уг шийдвэр хүчин төгөлдөр болсон.
2. Компанийн ТУЗ-ийн 2023 оны төсвийг батлах асуудлаар нийт ирүүлсэн саналын тоо 332,905 үүнээс татгалзсан 84,712, хүчингүй 3, зөвшөөрсөн 248,910 нь нийт ирүүлсэн саналын 74,55% болсноор уг санал хүчин төгөлдөр болсныг тус тус мэдэгдсүгэй.

ТУЗ-ийн дарга Аюуш:

За тооллогын комиссын тогтоолыг үндэслээд, хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарах тогтоолын төслийг танилцуулъя.

Төсөв батлах тухай

Компанийн тухай хуулийн 62.1.9 болон 62.1.13 заалт, ТУЗ-ийн дүгнэлт, ХЭХ-ын тооллогын комиссын 2-р тогтоолыг үндэслэн тогтоох нь:

1. Компанийн 2022 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-ийн дүгнэлтийг баталсугай.
2. Компанийн ТУЗ-ийн 2023 оны зардлыг хавсралтаар баталсугай.

За ингээд хурлын ажиллагаа дууссаныг мэдэгдье.

Хурлын дарга З.Цэрэнчимэг

Хурлын тэмдэглэл хөтөлсөн.

Хүний нөөцийн ахлах менежер
Нягтлан бодогч



Undrag

Г.Алт-Ундрах,
М.Гэрэлцогт

2023.04.27